



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/347

Булган сум

Волейболын идэрчүүдийн Аймгийн аварга
шалгаруулах тэмцээнд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.9 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Волейболын спортыг сурталчлан таниулах, идэрчүүдийн авьяас, ур чадварыг сайжруулах зорилгоор Тэшиг суманд зохион байгуулагдах волейболын аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 3,000,000 (гурван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардлыг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

